

Өмнөговь аймгийн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн тусламж

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

/2019 оны 6 сарын байдлаар/

	Үзүүлэлт	<u>БОЭТ</u>	Сумдын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Цэргийн анги	Нийт аймгийн дүн
1	Нийт үзлэг	64290	60317	42626	21174	1807	190214
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	26383	21481	15769	2159	1529	67321
3	Идэвхтэй хяналтын үзлэг	5839	11448	9463	1289		28039
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	16593	12094	7076	4753	273	40789
5	Нийт төрөлт	625	153				778
6	Хэвтэн эмчлүүлэгчид	4209	2639		1315	17	8180
7	Нас баралт	20	93	56			170

1. Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 190214 хүнд үзлэг шинжилгээ хийсний 50.1%-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
2. Ортой эмнэлгүүдэд нийт 8180 хүнийг 54411 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.6 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
3. 6 сарын байдлаар 40789 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6745 тохиолдлоор өссөн байна.
4. Эхний 6 сарын байдлаар 607 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 30 хүн нас барсан нь өнгөрсөн оноос өвчлөл 90 тохиолдлоор буурч, осол гэмтлийн нас баралт 7-р тохиолдлоор өссөн байна. Осол гэмтлээр нас барагсдын 30%/9/нь амиа хорлож/Гт-1,Мо-1,Мн-1,Но-1,Сэ-1,Хх-1,Хб-1,Эу-2/ 26,6%/8/нь зам тээврийн осол,/Но-2,Сэ-1,Хү-1,ЦЦ-1,Эх-1,Эу-1,БОЭТ-1/, 36,6%/11/ нь бусад ослоор/хөлдсөн-7-Сэ-2,Хб-1,Хх-1,Цц-2,Эх-1,архины хордлого-Гт-2,Эх-1,зодуулсан-Но-1/ 6,6%/2/бусдад хорлогдсон-/Но-1/,Хб-1/ тус тус эндсэн байна. Осол гэмтлээр нас барагсадын 83,3% нь эрэгтэй хүмүүс эндсэн байна. Мөн ослоор эндэгсдийн 63,3% нь эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүйн дээр эмнэлэгт нас барсан 66,6%/6/ хүний /өөрийгөө буудсан-1, хөлдсөн-1,бусдад хорлогдсон-1, архины хордлого-1 нийт-4 хүн/хүнд гэмтлийн улмаас хоног болоогүй нас барсан байна. Нийт осол гэмтлийн нас баралт:Гт-3/амиа хорлосон-1,хөлдсөн-1,зам тээврийн ослоор-1/,Мо-1/амиа хорлосон-1/,Мн-1/амиа хорлосон-1/,Но-3/зам тээврийн осол-2, бусдад хорлогдсон-1/,Сэ-4/хөлдсөн-2,амиа хорлосон-1,зам тээвэр-1/,Хх-2/амиа хорлосон-1,хөлдсөн-1/,Хб-3/амиа хорлосон-1,хөлдсөн-1,бусдад хорлогдсон-1/,Хү-2/зам тээврийн осол-2/,ЦЦ-1/зам тээврийн осол-1/Эх-

- 2/архинд хордсон-1,хөлдсөн-1/Эу-5/амиа хорлосон-2,зам тээвэр-1, хөлдсөн-2/БОЭТ-3/бусдад хорлогдсон-1,зам тээвэр-1,юманд цохигдсон-1/
5. Оны гарсаар 170 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 17,6% нь осол гэмтлээр, 23,5% нь хорт хавдраар 6.4% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт/Бо-1,Хх-3,Цо-2,Шб-2,Өо-1,Эх-1,Эу-1/ зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 7% /Хб-5,Гт-4,Мн-1,Бг-1/нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
 6. Нялхсын эндэгдлийн 15/Гт-4,Хб-5,Цц-1,Мн-1,Эх-1,Бг-1,Нн-2,/тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 19,2 байна.
 7. Түргэн тусламжийн 6421 дуудлагад явж үйлчилсний 939/14.6%/ нь алсын дуудлага, 340/5,3%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 95.7% -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
 8. 6 сард 4507 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 66,2% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 9 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,2%-г эзэлж байна.
 9. Нийт 778 эх төрж 781 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 47 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 6% охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Бо-2,Бу-2,Гт-3,Мн-3,Но-2,НН-1,Сэ-2,Хб-1,Хх-3,Хү-1,Цц-4,Шб-5,Өо-10,Эх-4,Бг-3/.
 10. 6 сарын байдлаар 353 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 452 байгаа нь өнгөрсөн оноос 1,3% буурсан үзүүлэлт байна.Өсвөр насны охидын үр хөндөлт 5,6%/Бд-1,Бу-2,Мо-1,Мн-1,Но-2,Нн-1,Сэ-1,Хб-3,Хх-1,Хү-1,Шб-2,Өо-1,Эх-2,Бг-1/ байна.
 11. Он гараад 196 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 236 тохиолдлоор буурсан байна. Нийт халдварт өвчний 25%-г салхинцэцэг, 10,2%-г улаанэсэргэнэ өвчин, 45,4%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
 12. ЭЭСангуудад нийт 9372 жор ирсний 50.2%/4709/нь ЭМДаатгалын, 0,1%/10/ мансууруулах эмийн, 1,8% /175/ сэтгэц нөлөөт эмийн, 47.7% /4478/ нь энгийн эмийн жор байсан ба 1% /102/нь алдаатай жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 77,1% байна.
 13. БОЭТөвд 20 эндэгдэл тохиолдож 5 эндэгдэлийг онош тодорхой, өндөр настан, ар гэрийн хүсэлтээр гэсэн шалтгаанаар задлан шинжилгээнд хамруулаагүй ба задлан шинжилгээний хувь 75% тай байна. Үндсэн оношийн зөрөө 2%.